# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

We ensure
Product safety
Cosmos Tech Mongol

WE ENSURE PRODUCT SAFETY

### Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нийлүүлэлт

Манай компани Ази, Америк, Европийн орнуудын эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаатай байдаг бөгөөд тэр дундаас олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, чанарын гэрчилгээтэй, хэрэглэгчдийн үнэлгээ өндөр, тэргүүлэгч үйлдвэрүүдийг сонгодог тул хэрэглэгчдэд үргэлж чанартай бүтээгдэхүүнийг хүргэсээр ирсэн.
Бид таны хэрэгцээ шаардлагыг сайтар тунгаан бодолцож, танд хамгийн тохиромжтой бүтээгдэхүүнийг боломжит доод үнээр хангаж нийлүүлэх болно.

### Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт

Та бүхний захиалсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг ашиглах газарт тань стандарт, шаардлагын дагуу бүрэн суурилуулалт хийж үйлчилнэ. Мөн хэрэглэгчиддээ зориулж Монгол хэлнээ орчуулсан ашиглалтын гарын авлагыг дагалдуулж, зөв зохистой ажиллуулах сургалтыг явуулдаг тул тоног төхөөрөмжийг буруу ашигласнаас болж үүсэх эрсдэлийг багасгаж өгдөг.

### Гэрээт засвар үйлчилгээ

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага таны, хэрэглэж буй тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, учирсан гэмтлийг туршлагатай инженерүүд, болон чадвартай эрч хүчтэй инженер залуучуудын баг хамт олон маань оношилж, засвар үйлчилгээг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.

### Сургалт, зөвлөгөө

Космос Тек Монгол компани нь шинээр нэвтрүүлж буй тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи бүрдээ сургалт, семинарыг тухайн салбарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулдаг бөгөөд олон улсад хэрэглэгдэж буй шинэ технологитой хөл нийлүүлэн алхах боломжийг бий болгож байгаадаа сэтгэл хангалуун байдаг билээ.

## КОСМОС ТЕК МОНГОЛ ХХК

+97670117038
/ctm.mongolia
СБД, 8-р хороо, Бага тойруу, GB Center, 202 тоот

COSMOS




WE GO BRIGHT FUTURE

### Бидний зорилго

*Монголын эрүүл мэндийн салбарт дэлхийн дэвшилтэт шинэ технологийг судалгааны үндсэн дээр нийлүүлэн сурталчлах улмаар монголд нутагшуулах чиглэлд гол үйл ажиллагаагаа хандуулан ажиллана.*

Таны хүсэл сонирхлын дагуу, хамгийн тохиромжтой бүтээгдэхүүнийг, боломжит хямд үнээр санал болгож, мэргэжлийн түвшний цогц үйлчилгээг үзүүлэх бүтээлч хамт олон бид,
**Тантай хамтарч ажиллахад таатай байна**

"Космос Тек Монгол" ХХКомпани нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш япон, солонгос, хятад, канад, орос, америк зэрэг орнуудын томоохон үйлдвэрлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд, Монгол улсад ажиллаж буй улсын болон хувийн эмнэлгүүдэд Эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, багаж тэргүүтнийг голчлон нийлүүлж ирсэн.

Бид эрүүл мэндийн байгууллагад судалгаа шинжилгээн дээр тулгуурласан орчин үеийн шинэ технологийг сурталчлан нийлүүлэх,улмаар эмчилгээний шинэ технологийг монголдоо нутагшуулах их үйлсэд хоёргүй сэтгэлээр зүтгэж буй хамт олон болно. Үүний нэгэн жишээ Монголдоо анхны Ясны чөмөг цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний технологи, Үр шилжүүлэн суулгах эмчилгээний технологи, Цус цусан бүтээгдэхүүний чанарыг сайжруулах технологи зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийгэмд зайлшгүй шаардлагатай ирээдүйд эрүүл мэндийн салбарт үсрэлттэй дэвшил авч ирэх технологийг нэвтрүүлэхэд гар бие мэдлэг ухаанаа дайчлан байгаа билээ.

Олон жилийн туршлагатай инженерүүд болон эрч хүчтэй, шинийг эрэлхийлэгч залуус хамтран нэг баг болж бүрдсэн тул аливаа асуудлыг бүтээлч сэтгэлгээтэй, маш хурдан шийдэж ажилладаг билээ. Мөн бид орчин үеийн шинэ техник технологи өдөр ирэх тусам хөгжиж байдагтай холбогдуулан ажилчдаа харилцагч компани, үйлдвэрүүд дээрээ тогтмол сургалтанд хамруулж, ирээдүйн эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиг хандлагад туушгай судалгаа хийж зөвхөн залуусынхаа мэдлэгийг дээшлүүлэх үйлсэд тус нэмэр оруулахыг хичээж явдаг.

### Бидний нэвтрүүлсэн дэвшилтэт технологиуд


COBE SPECTRA
Apheresis System


WAVE SYSTEM 4500HT
Nucleic Acid Fragment Analyzer


BDFACSCanto II
Flow Cytometry Analyzer System


MIRASOL PRT
Phatogen Reduction Technology


RAY CELL MK2
X-ray Blood Irradiator


SPECTRA OPTIA
Apheresis System

### Харилцагч байгууллагууд

TERUMOBCT
dongmun
WEGO 威高
bistos
ecotron eco & electronics
sebia electrophoresis
BIOBASE
PERLONG

COSMOS